



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/132/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: С.Санчирмаа
	Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 105

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын захирамжаар "Нээлттэй Алтай" хөтөлбөрийн хүрээнд шинээр гэр бүл болсон малчин залууст дэмжлэг үзүүлж өрх тус бүрийг 50 толгой эм ямаагаар малжуулах ажлыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 174,476.8 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 6 зорилт 117 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 93 арга хэмжээг бүрэн, 14 арга хэмжээг 90.0 хувь, 4 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээ 50.0 хувь, 5 арга хэмжээ 30.0 хувьтай буюу нийт дүнгээр 92.7 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Дэлгэр сумын Засаг дарга 93.7 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702900322

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	143,984.4	155,167.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,165,519.2	4,774,255.7
	Нийт хөрөнгийн дүн	1,309,503.6	4,929,423.2
	Нийт өр төлбөрийн дүн	-	14,722.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,309,503.6	4,914,701.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,309,503.6	4,929,423.2
	Үйл ажиллагааны орлогын дүн	710,348.1	4,335,442.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	510,021.2	730,244.9
	Үйл ажиллагааны үр дүн	200,326.9	3,605,197.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	10,973.4	0.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	189,353.5	3,605,197.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,119,008.72	1,309,503.60
	НББ-ийн өөрчлөлт	1,141.42	-
	Тайлант оны үр дүн	189,353.46	3,605,197.55
	Эцсийн үлдэгдэл	1,309,503.60	4,914,701.15
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	480,146.7	865,090.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	419,347.2	557,465.8
	Үйл ажиллагааны ЦМГ	60,799.4	307,625.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(60,799.4)	(307,625.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	619,322.6	597,312.6
	Урсгал зардал	523,822.6	502,434.6
	Хөрөнгийн зардал	95,500.0	94,878.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	619,322.6	619,349.6
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	619,322.6	619,349.6

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1,530,334.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Биет бус хөрөнгийг 1,530,334.0 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 5,954.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,954.2 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 1,971.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1 албан шаардлага өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогчийг тайланд онд биеэр ээлжийн амралт эдлүүлээгүй байхад ээлжийн амралтын урамшуулал 1,671.0 мянган төгрөгийг олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын нөхөн олговор болох 1,671.0 мянган төгрөгийг ажилтанд буцаан олгох төлбөрийн акт тогтоосон.

2. Ажилтнаас 300.0 мянган төгрөгийн актыг суутгасан боловч аудитын орлогын дансанд төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төвлөрүүлээгүй 300.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс аварга малчныг шагнахад 1,895.0 мянган төгрөгийг, эх үрсийн баярт зориулсан 938.2 мянган төгрөгийг, төрийн дээд шагналаар шагнагдсан хүмүүст 1,150.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	1	1.5	-	-	1	1.5	1	1.5	-	-	-	-
Дүн	1	1.5	-	-	1	1.5	1	1.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газар	3	6.0	2	2.0	1	4.0	-	-	-	-	-	-
Дүн	3	6.0	2	2.0	1	4.0	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			